

МОНГОЛ-ДАНИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

Д. Тунгалаг¹

Монгол улсын дээд боловсролын тогтолцоо

Илтгэлийнхээ эхэнд Монгол улсын дээд боловсролын тогтолцоо, түүний дотор олон улсын харилцааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа талаар товч ярья. Монголын дээд боловсролын байгууллага нь төрийн өмчийн болон төрийн өмчийн бус гэж хоёр хуваагддаг ба БСШУЯ-нд харьяалагддаг.

Нийт төрийн өмчийн 60, төрийн өмчийн бус (хувийн) 116 их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд сургалт явуулж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагыг дотор нь 3 ангилдаг. Үүнд:

- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
- Дээд сургууль, коллеж
- Их сургууль

Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, суралцагчид

Higher educational institutions and students

Сургалтын байгууллагын ангилал <i>Classification of higher educational institutions</i>	Сургалтын байгууллагын тоо <i>educational institutions</i>	Суралцагчдын тоо (мян.хүн) <i>students thous. persons</i>
Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв <i>Universities, institutes, colleges, technical and vocational schools</i>	176	216,9
Төрийн өмчийн: <i>Public:</i>	60	139,1
мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв <i>technical and vocational schools</i>	44	34,7
дээд сургууль, коллеж <i>institutes, colleges</i>	7	6,0
их сургууль <i>universities</i>	9	98,4
Төрийн өмчийн бус: <i>Private:</i>	116	76,7

¹ МУИС-ийн ОУХ-ийн профессор, доктор (Ph.D)

мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв <i>technical and vocational schools</i>	19	11,4
дээд сургууль, коллеж <i>institutes, colleges</i>	88	49,2
их сургууль <i>universities</i>	4	16,1

Монгол улсын 1000 хүн тутмын 62 нь ямар нэгэн их, дээд сургууль, коллежид суралцаж байна.

Одоо МУИС, түүний дотор Олон улсын харилцааны сургуулийн талаар товч танилцуулья.

МУИС бол төрийн өмчийн 9 их сургуулийн нэг бөгөөд бүрэлдэхүүн 16 сургуультай, 10 мянга орчим суралцагчидтай. Тэдгээрийн нэг нь манай Олон улсын харилцааны сургууль. ОУХС анх 1991 онд байгуулагдсан. Нийт 800 орчим суралцагчидтай.

ОУХС-ийн сургалтын түвшин, мэргэжлийн чиглэл

Сургалтын түвшин	Мэргэжлийн чиглэл	Суралцах хэлбэр	Багц цаг	Суралцах хугацаа
Бакалаврын сургалт	• олон улсын харилцаа • олон улсын эдийн засгийн харилцаа	өдөр	120	4
Магистрын сургалт	• олон улсын харилцаа • олон улсын эдийн засгийн харилцаа • олон улсын эрх зүй	өдөр эчнээ	30	2-3
Докторын сургалт	• олон улсын харилцаа, олон улсын эдийн засгийн харилцаа, олон улсын эрх зүйгээр	экстернат өдөр эчнээ	60	1-4,5

Олон улсын харилцааны сургууль нь олон улсын байгууллагууд, гадаадын их, дээд сургууль, хүрээлэн төвүүдтэй идэвхтэй, өргөн хүрээтэй хамтын ажиллагаа, харилцаа холбоо тогтоон ажилладаг. Үүнд:

- Дипломатын Академиуд, Олон улсын харилцааны сургуулиудын Дэлхийн Холбоо,
- АНУ-ын Гадаад хэргийн мэргэжлийн сургуулиудын холбоо (АПСИА),
- Японы Фукухара Гакуены Консорциум,
- НҮБ-ын Их сургууль, Нидерландын Олон улсын харилцааны институт (Клингендал),
- Москвагийн Олон улсын харилцааны институт (МГИМО),
- БНХАУ-ын Олон улсын харилцааны институт,
- АНУ-ын Колумбийн Их сургуулийн Олон улсын харилцааны сургууль (SIPA),
- Өрнөд Коннектикут мужийн их сургууль (АНУ),
- Вьетнамын Олон улсын харилцааны дээд сургууль,
- Энэтхэгийн Хятад судлалын институт,
- Жавахарал Неругийн Их сургуулийн Олон улс судлалын дээд сургууль,
- Каирын их сургуулийн Азийн судлалын төв (Египет),

- БНСУ-ын Инха (INHA) Их сургуулийн Олон улсын харилцааны төв,
- БНСУ-ын Сонгюнь-Гуань их сургууль,
- Францын Ле-Хаврегийн их сургууль,
- БНХАУ-ын Өвөр Монголын их сургууль,
- Тайваний Азийн их сургуулийн Менежментийн сургууль гэх мэтийг нэрлэж болно.

Дани улсын дээд боловсролын тогтолцоо

Одоо Дани улсын дээд боловсролын тогтолцооны талаар товч ярья.

Дани улс нь хүчтэй эдийн засагтай, дээд боловсролын маш өндөр түвшинтэй Скандинавын жижиг улс билээ. Данийн боловсролын систем төрийн бүрэн хяналтанд байдаг. Дээд боловсролын байгууллага нь үндсэндээ төрийн байгууллага бөгөөд Боловсролын яам, эсвэл Соёлын яамандаа харьяалагддаг.

Данийн дээд боловсролын давуу тал:

- Боловсролын үйл явцыг динамик, инновацийн соёлтой хослуулан судалгаа шинжилгээний ажил болон сургах арга зүйд суурилсан Данийн мэргэжлийн боловсрол нь дээр үеэс уламжлалтай
- Боловсролын өндөр стандарттай, онолын мэдлэгээ практикт идэвхтэй ашигладаг, суралцагчдыг судалгааны ажилд идэвхтэй оролцуулдаг
- Англи хэл дээр олон тооны хөтөлбөртэй
- Тухайн орны хүн ам англи хэлээр чөлөөтэй ярьдаг
- Дани улс нь дэлхийд авилгалын түвшингээр хамгийн бага, Шинэ Зеландын дараа ордог

Данид дээд боловсролын байгууллагыг дотор нь 3 ангилдаг. Үүнд:

Мэргэжлийн сургууль

- Бизнес, технологи, мэдээллийн технологийн салбарт мэргэжил олгох 2 зуны хөтөлбөр
- Онол ба судалгааны ажлын сургалтыг олсон мэдлэгээ практикт ашиглахтай хослуулдаг
- Сургалдтын төгсгөлд 3 сарын хугацаанд судалгааны ажил хийдэг

Коллеж

- Тусгай мэргэжлийн коллеж, дээд боловсролын төвүүд, мөн их сургуулийн коллежууд бизнес, боловсрол, инженерийн соёлын салбаруудын 3-4 жилийн хугацаатай хөтөлбөрүүдийг санал болгодог
- Онолын судалгаа, практикт суралцах, бакалаврын зэрэг авах судалгааны ажил зэрэг нь сургалтын хөтөлбөрийн салшгүй чухал хэсэг нь болдог

Их сургууль

- Их сургуулиуд оюутнуудыг сургах, олон улсын түвшинд хамгийн чанартай судалгаа хийлгэх үүрэг хүлээдэг
- Зарим их сургуулиуд хэд хэдэн факультетад олон тооны төрөл бүрийн сургалтанд хамруулах санал тавьдаг
- Харин зарим их сургуулиуд ямар нэгэн тодорхой салбарт мэргэшүүлдэг

Дани улсын дээд боловсролын сургалтын түвшин

Курс	Үргэлжлэх хугацаа	Зэрэг
Суурь	3 жил	Бакалавр (байгалийн болон хүмүүнлэгийн шинжлэх ухааны бакалавр)
Үндсэн	2 жил	Магистр (байгалийн болон хүмүүнлэгийн шинжлэх ухааны магистр)
Нэмэлт	3 жил	Доктор (философийн доктор)

Бакалавр

- Хоёр үндсэн хичээлд илүү анхааран 3 жил суралцдаг, бакалавраа төгсөөд мэргэжлээрээ ажиллах эрхтэй, магистрт үргэлжлүүлэн суралцах эрхтэй.

Магистр

- Бүтэн 5 жил суралцсаны дараа магистрын зэрэг олгодог.

Доктор

- 3 жил суралцаад PhD докторын зэрэг авдаг.

Цаашид хамтран ажиллах талаар

- Олон улсын харилцааны чиглэлээр сургалт явуулдаг Данийн их, дээд сургуулиудыг судалж холбоо тогтооход Монгол-Данийн нийгэмлэгээс дэмжлэг авах
- Ингэснээр:
 - Харилцан туршлага солилцох,
 - Оюутан солилцох,
 - Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх,
 - Нарийн мэргэжлийн ном, сурах бичиг, сургалтын материал солилцох зэргээр хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж нээлттэй болох юм.

МОНГОЛ, ДАНИЙН ИРГЭДИЙН АРДЫН ДИПЛОМАТ ХАРИЛЦААНЫ ТҮҮХЭЭС

Н.Тунгалаг¹

Нэг.

Өнгөрсөн зууны эхээр Данийн зарим нэгэн инженер, судлаачид, жуулчид болон аж ахуй эрхлэгчид Монгол орныг сонирхож харилцаа холбоо тогтоож байсныг тэмдэглэл, дурсамж яриа, ном зохиолоос харж болно (Элчин сайд асан Кристофер Бо Брамсены дурсамж, ах дүү-Карл Кревс, Ове Кребсийн тэмдэглэл, Хеннинг Хаслунд Кристенсены бүтээлүүд “Далд Монгол”, “Явнаа”, “Бурхад ба эрчүүд”).

Хоёр. 1980-аад оны сүүлчээр Монгол иргэд Дани хүмүүстэй харьцаа холбоо тогтоож эхэлсэн. Ард иргэдийн энэхүү харьцаа нь хувь хүмүүс хоорондын харьцаанд тулгуурлаж улмаар өргөжин тэлж зохион байгуулалтын хэлбэрт шилжсэн. 1990 онд Дани улсын Копенгаген хотноо нэрт аялагч Ёрген Битч, Хатан хааны маршал Сорен Кристенсен, монголч эрдэмтэн Рольф Гильберг, эдийн засагч Лайф Петерсен, социологч Нямаагийн Булган, архитектор Яан Коед нар Дани-Монголын нийгэмлэгийг үүсгэн байгуулсан. 1989 онд Улаанбаатар хотноо хэсэг монгол нөхөд Монгол-Данийн нийгэмлэгийг үүсгэн байгуулах талаар хэлэлцэж 1990 онд албан ёсоор тус нийгэмлэгийг бүртгүүлсэн. Тус нийгэмлэгийг Ш.Цог, Н.Тунгалаг, Д.Чинбат, Ж.Нямаа, Т.Батжаргал, Д.Отгончимэг, Б.Батчулуун нар санаачлан байгуулж байжээ.

I Кристофер Бо Брамсены яриа, ах дүү Кребсийн тэмдэглэл, Хеннинг Хаслунд Кристенсены бүтээлээс

- Өнгөрсөн зууны эхээр Данийн харилцаа холбоо, уул уурхайн салбарын инженер, судлаачид, аж ахуй эрхлэгчид Монгол орныг зорин ирж тодорхой хугацаанд аж төрж аж ахуй эрхэлж байсныг хожим нь үр хүүхдүүд нь дурсан тэмдэглэжээ. Тухайлбал, Бээжин дэх Данийн Элчин сайд асан Кристофер Бо Брамсен Да хүрээнд түүний эцэг оршин сууж аж ахуй эрхэлж байсан тухай Монгол-Данийн нийгэмлэгийн гишүүдтэй уулзаж байхдаа мэдээлж байсан.
- Монгол судлаач Хеннинг Хаслунд Кристенсены 100 жилийн ойд зориулж монгол хэлнээ орчуулсан “Далд Монгол” номонд /Улаанбаатар 1996/ Данийн дөрвөн зоригтой эрс олон мянган бээрийг алгасан Монголын өргөн уудам нутаг орноор олон сар, жилээр аялан нүүдэлчдийн соёл иргэншилтэй танилцаж улмаар Хөвсгөлийн өнөөгийн Эрдэнэбулган


¹ МДН-ийн тэргүүн

суманд аж төрөн амьдарч байсан тухай өгүүлжээ. Түүнчлэн эрдэмтэн, аялагч Карл Кребсийн үр хүүхдүүд - Карл Кребс, Ове Кребс нарын хувийн тэмдэглэлээс үзэхэд Дани хүн дэлхийн 1-р дайны үед Монгол оронд ирж байсан байна. Тэдний Монгол оронд амьдарч байсан үеийг дараах байдлаар тодорхойлж болмоор байна. Үүнд:

- ✓ Дэлхийн 1-р дайны үе – Анагаах ухааны боловсролтой, олон талын туршлага мэдлэгтэй, цэргийн сургуулийг дүүргэсэн Карл Кребс хэмээх Дани залуу Улаан загалмайн нийгэмлэгт ажиллаж байхдаа Данийн үеэр олзлогдсон хоригдлуудад тусламж үзүүлэх ажлыг эрхэлж байсан байна. Тэрээр Оросын Сибирийн шоронгуудыг шалгаж Байгаль нуураас Бээжин хүртэл луужингаар ганцаараа говь талаар аялж байхдаа хорт могойнд хатгуулж Булган талд саатаж Монгол хүнээр туслуулж амьд мэнд гарч байсан байна. Монголын үзэсгэлэнт байгаль, ард иргэдийн тусламтгай зан чанарыг биширч Дани нутагтаа ирээд газар зүйн нийгэмлэг болон анд нөхөд, олон нийтийн хэвлэлээр Монгол орны талаар мэдээлэл гаргаж байжээ.
- ✓ 1919-1920 он – Карл Кребс Булган талд дахин ирж Монгол орны байдлыг нарийвчлан судалсан.
- ✓ 1920-1923 он – Карл Кребс нь Монгол орноор аялах сонирхол нь улам ихсэж экспедицийн баг бүрдүүлэх сурталчилгааг явуулж байлаа. Тэрээр Монгол орноор аялах хүсэлтэй 400 орчим хүнээс өргөдөл авсан боловч зовлон бэрхшээлийг туулах чадвартай, өөрийн сайн таних 6 хүнийг сонгож аяллын гэрээ хэлэлцээрийг хийж бэлтгэл ажилдаа орсон. Аяллын бүрэлдэхүүнд Карл Кребсээс гадна цэргийн сургуулийг түүнтэй хамт дүүргэсэн онцгой тайван зан чанартай хожим нь Монгол судлаач болсон Хеннинг Хаслунд Кристенсен, найзархаг, түүхийн мэдлэг сайтай, нөхөрсөг Воргостром, политехникийн багш Брик, хөдөө аж ахуйг сайн мэддэг Эрик Исагер, сайн инженер, офицер Ове Кребс нар багтаж байсан. Гэвч Эрик, Ове нар Монгол явж чадаагүй.
- ✓ 1923 он – Экспедици нь 1923 оны 3 сараас Данийн Копенгаген хотоос эхэлж 1923 оны 11 сарын 18-нд найман сарын дараа Хөвсгөл нутгийн Булган талд иржээ. “... цэлийсэн сайхан уудам тал Биднийг энэ их халиуран давалгаалсан өвс ногоотой талд жаргаж байгаа улаан наран, битүү модтой хүйтэн оргилууд хүлээж байлаа. Бид салхинд урагдсан Данийн тугаа тал дунд намируулж, калибрь буугаар гурвантай буудсан билээ. Бид энэ өдрийг хэзээ ч мартахгүй....” гэж экспедицийн гишүүн Хеннинг Хаслунд тэмдэглэлдээ бичжээ. Энэхүү тэмдэглэлийн талаар түүний хүү, хожим нь Хатан хааны маршал, Дани улс дахь Монголын консул Сорен Хаслунд өгүүлж байсан.
- ✓ 1923-1926 он – Булган талд суурьшин амьдарсан. Фермерийн ажил эрхэлж, шинэ буудайн сортыг нэвтрүүлж газар тариалан эрхэлж, нутгийн ард иргэдэд хүнсний ногоо тариалах, гахай, тахиа, загасны аж ахуй эрхлэхийг зааж сургаж, хүнсний ногоо хэрэглэхийг зөвлөж нутгийн хүмүүст эмнэлгийн анхны туслалцаа үзүүлж байсан. Мөн усжуулалтын систем байгуулж тээрэм суурилуулсан. Даничууд чихрийн манжин тариалж элсэн чихрийг үйлдвэрлэдэг байжээ. Булган талд Европын соёл иргэншлийг түгээж суурин газрыг богино хугацаанд байгуулж байсан байна. Нутгийн ард иргэдтэй богино хугацаанд ойртож худалдаа арилжаа хийж нөхөрсөг харьцаа тогтоож байсныг хожим нь Эрдэнэбулган сумын ахмадууд дурсан ярьдаг билээ.

- ✓ 1926 оноос–Булган талаас экспедицийн зарим нэгэн гишүүд нь буцсан. Экспедицийн ахлагч Карл Кребс энэ нутагт аж ахуйгаа өргөжүүлэн амьдарч байгаад 1936 онд тухайн үеийн улс төрийн байдлаас болж хэлмэгдэж Монголоос хүчээр нутаг руугаа буцсаныг түүний тэмдэглэлээс үзэж болно.
- ✓ Нутгийн иргэд Карл Кребсийг тусч бөгөөд сайн эмч, сайн зохион байгуулагч байсныг дурсан санадаг билээ. Тэрээр нутагтаа буцаж ирээд Монголчуудын зочломтгой зан чанарыг тэмдэглэж байжээ. Карл Кребс нь Монгол орныг сайн таньж мэдсэн, Монгол, Данийн ард иргэдийн ардын дипломат харьцааг үүсгэн байгуулахад тодорхой хувь нэмрээ оруулсныг Эрдэнэбулган сумын ахмад иргэдийн дурсамж ярианаас харж болох юм. Түүнийг Данск орос эмч гэж нутгийн иргэд дуудаж хүндэлдэг байжээ. Тэрээр олон салбарын мэдлэгтэй хүн байсан ба тэр дундаа газар зүйн томоохон судалгааг хийж, нээлт гаргасан байна. Ази тив Австрали тив нэг урсгалтай гэсэн онол гаргажээ. Одоо тэр нь батлагдаад түүний нээлтийг Дани улсын дунд сургуулийн газар зүйн хичээлээр заадаг болсон байна. Түүнчлэн аялагч Хеннинг Хаслунд Кристенсен Төв Ази, тэр дундаа монголчуудын соёл иргэншлийн талаар томоохон бүтээлүүдийг туурвиж нутагтаа буцаж ирээд Монголын талаар ховор нандин, ихээхэн цуглуулгыг бий болгож Данийн Хатан хааны музейд хандивласан байна. Тэрээр монголчуудын талаар ховорхон үзмэрүүдийг бий болгож чадсан нь Даничуудад Монголын түүх, соёлыг түгээхэд томоохон хувь нэмрээ оруулсныг илэрхийлж байна.

Карл Кребсийн тухайн үеийн хувийн зургийн архиваас



Хоёр. 1989 оны төгсгөл

Монгол-Данийн Нийгэмлэг (МДН) байгуулах асуудлыг хэсэг бонгол нөхөд анх 1989 онд хэлэлцэж, улмаар 1990 онд албан ёсоор байгуулжээ. Монгол-Данийн нийгэмлэг нь Дани дахь Дани-Монголын нийгэмлэг (ДМН) байгуулагдсаны хэдэн сарын дараа үүсэн бий болж хамтын ажиллагаагаа эхэлсэн.

МДН нь 250 гишүүдтэй, Хөвсгөлийн Эрдэнэбулган сум, Төв аймгийн Дэлгэрхаан сум, Эрдэнэ суманд салбартай, УБ хотын 5 дүүрэг, 10 аймагт дэмжигчидтэй.

Монгол-Данийн Нийгэмлэгийн зорилго

1. Хоёр орны ард иргэдийн болон холбогдох байгууллагуудын харилцааг хөхүүлэн дэмжиж хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах

2. Дани-Монголын нийгэмлэгтэй хамтарч Монголын нийгмийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах
3. Хоёр орны түүх, соёл, хөгжлийн туршлага болон бусад мэдээ мэдээллийг түгээн дэлгэрүүлэх

Үйл ажиллагаа:

1. **Хоёр орны ард иргэдийн харьцааг дэмжих, холбогдох байгууллагуудыг холбох чиглэлээр дараах үйл ажиллагааг явуулж байна.**
 - 1990 оноос эхлэн хоёр орны ард иргэдийн найрамдалт харьцааг дэмжин сонирхогч иргэд хооронд зуучлах үйл ажиллагааг явуулж байна.
 - Хоёр орны ард иргэдийн уламжлалт харьцааны талаарх түүхэн баримт, мэдээллийг цуглуулж холбогдох байгууллагууд болон ард иргэдэд түгээж байна.
 - Монголын түүхийн музейг Данийн Хатан хааны үндэсний музейтэй холбох, үзмэр, үзвэрийг хадгалах Данийн технологийг судлах, мэргэжилтэн солилцох асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлсэн.
 - Бизнесийн болон хөдөө аж ахуй, эрчим хүчний салбарын зарим нэгэн инженер, мэргэжилтэнг Данийн туршлагатай танилцуулах асуудлыг Дани-Монголын нийгэмлэгт тавьж байсан.
 - Монгол орныг сонирхогч Дани иргэдэд болон хэвлэл мэдээллийн хүмүүст дэмжлэг үзүүлж Монголд аялаж зочлоход нь тусалж байна.
2. **ДМН –тэй хамтран нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дараах үйл ажиллагаа зохион байгуулж байна.**
 - 1995 оноос хойш Монголын нийгмийн эмзэг бүлэг - Хараа хяналтгүй хүүхдүүдийн асуудлыг судалж Дани-Монголын нийгэмлэг, МХТҮГ-тай хамтран “Монголын хараа хяналтгүй хүүхэд” төслийг 1997 оноос хэрэгжүүлэхээр болсон. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага - ДаМоСТ (Дани - Монголын сургалт, арга зүй, судалгааны төв)-ийг үүсгэн байгуулж, түүний үйл ажиллагаанд нь дэмжлэг тусалцаа үзүүлсэн. Төсөлд эмзэг бүлгийн 2000 гаруй хүүхдүүд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг хамруулж, ахуй амьдралыг нь дээшлүүлж нийгэмшүүлэхэд эергээр нөлөөлсөн. Төсөл нь 1997-2007 он хүртэлх хугацаанд хэрэгжсэн.
 - Зудад нэрвэгдсэн Төв, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговь аймгуудын ард иргэдэд өвс, малын тэжээл, гурил, будаа, эм тариа, усжуулах систем, трактор зэргийг тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан зохион байгуулалттайгаар хүргүүлж байсан. Энэхүү тусламжийг Дани-Монголын нийгэмлэгийн гишүүд хандивласан ба тусламжийг санаачлах, түгээх ажилд МДН-ийн гишүүд идэвхтэй оролцсон.
 - Төв аймгийн Эрдэнэ сумын сургуульд “малжуулах” төслийг хоёр нийгэмлэг хамтран хэрэгжүүлсэн. Дани оронтой уламжлалт харилцаатай Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ард иргэдийг гэрэл цахилгаантай болгох талаар холбогдох байгууллагуудад зуучилж цахилгаан станц байгуулах эхний үе шатанд техник тусалцаа үзүүлж байсан.
 - Монголын авъяаслаг хүүхдийг дэмжих “Авъяас” хөтөлбөрийг 2008 оноос эхлэн ДМН –тэй хамтран зохион байгуулж байна. Үүнд: Орлого багатай гэр бүлийн

нийт 54 хүүхэд, залуучуудыг хамруулж тэдэнд их, дээд сургуулийн тэтгэлэг дэмжлэгийг олгож байна.

3. Хоёр орны туршлага, түүх, соёлоо харилцан таниулах, сурталчлах талаар дараах ажлыг хийж байна.

- Дани орны хөгжлийн туршлага, түүх, соёлыг монголчуудад таниулах, Монгол орноо Дани улсад сурталчлах, харилцан мэдээлэл солилцож байна.
- Данийн нэрт зохиолч Ханс Кристиан Андерсены төрсөн өдрийг хүүхдийн номын өдөр болгон тэмдэглэх уламжлалыг холбогдох байгууллагуудтай хамтран бий болгосон.
- “Дани орныг хэн сайн мэдэх вэ?” Хүүхдийн зургийн уралдааныг зохион байгуулдаг.
- Хөвсгөлийн Эрдэнэбулган суманд Дани иргэдэд зориулсан дурсгалын хөшөөг босгосон.
- “Нийгмийн Түншлэлийн Сүлжээ” ТББ-ын “Ярилцъя” сэтгүүл, ДМН-ийн “Гэр” сэтгүүл болон төвийн хэвлэл мэдээллээр Дани орны талаар мэдээ мэдээллийг өгч байна.

ДМН, МДН-ийн хамтын ажиллагаа

